



## НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар A/63

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгож,  
журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, 31.3.4, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.11, Төрийн болон бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн ажиллах журмыг нэгдүгээр, зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.


2.Журмыг мөрдөж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл (С.Цэдэнсодном)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн (А.Солонго)-д даалгасугай.

4.Энэ тушаал гарснаар Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн A/22 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МОНХБАТ



Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 08 сарын 10-ны өдрийн  
A/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь газрын өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, тооллого, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хөрөнгийн захиран зарцуулалтад тавих дотоодын хяналт, шалгалтыг зохион байгуулах үүрэг бүхий Өмч хамгаалах байнгын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын тушаалаар батална.

1.3. Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төр захиргааны байгууллагаас баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам болон бусад холбогдох хууль, тогтоомж, өмч хөрөнгөтэй холбогдон гарсан эрх зүйн баримтууд болон энэ журмыг мөрдлөг болгон ажиллана.

### Хоёр. Зөвлөлийн чиг үүрэг

2.1. Зөвлөл нь газрын эзэмшилд байгаа эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, өмч хөрөнгийг ариг гамтай ашиглаж үр ашгийг дээшлүүлэхэд байнгын хяналт тавьж ажиллана.

2.2. Зөвлөл нь үндсэн болон эргэлтийн хөрөнгийн бүртгэл хөтлөх, бүртгэлтэй хөрөнгийг шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах, устгах үндсэн хөрөнгийн талаар санал дүгнэлт гаргаж удирдлагад танилцуулах тайлагнах, холбогдох материалыг журмын дагуу бүрдүүлж, Нийслэлийн өмчийн харилцааны газар хүргүүлэн гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг газрын хэмжээнд зохион байгуулж ажиллана.

2.3. Зөвлөл нь тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор газрын даргаар батлуулна.

### Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Газрын үндсэн хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа зохион байгуулж, дутсан, үрэгдүүлсэн, ашиглалтгүй байгаа, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах

боловжгүй болсон хөрөнгийн шалтгааныг тогтоож, дүгнэлт гарган даргын зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

3.2. Газрын өмч хөрөнгийг өөрийн буруугаас эвдэж гэмтээсэн, үрэгдүүлж алга болгосон тохиолдолд буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

3.3. Ашиглагдахгүй байгаа ашиглах хугацаа дууссан буюу эвдрэл гэмтэлд өртсний улмаас зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон, сэлгэж засварлах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь нотлогдсон эд хөрөнгөд акт тогтоолгож, данснаас хасах санал дүгнэлтийг Даргын зөвлөлд танилцуулж, Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

3.4. Газрын удирдлага нь зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг ажлын байрны тодорхойлт болон Хөдөлмөрийн гэрээнд тусгаж, ажиллах нөхцөл бололцоогоор ханган ажиллана.

3.5. Зөвлөл нь үндсэн хөрөнгөд хийгдсэн засварын ажилд хяналт тавьж ажиллана.

### **Дөрөв. Зөвлөлийн хурал**

4.1. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна.

4.2. Зөвлөлийн хуралдаан ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байх ба ээлжит хуралдааныг хагас жил тутамд, ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын товлосоноор гишүүдийн 70%-ийн оролцоотойгоор удирдлагын санал болгосоноор зарлан хуралдуулна. Тус хуралдаанаар газрын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар, шинээр хөрөнгө бэлтгэх зэрэг асуудлыг хэлэлцэн, дүгнэлт гаргаж, хийсэн ажлын тайланг Удирдах Зөвлөл болон Даргын зөвлөлд танилцуулна.

4.3. Зөвлөлийн хурлаас шийдвэр гаргах бөгөөд хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Тав. Хариуцлага**

5.1. Газрын өмч хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр гадагш гаргах, хувьдаа ашиглах, эвдэж гэмтээх, бусдад шилжүүлэхийг хориглоно.

5.2. Энэ журмыг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.



Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 08 сарын 10-ны өдрийн

2/63

дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

### ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

ГИШҮҮД:

САНХҮҮ, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

БАРИЛГЫН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

ТЕХНИК ХАНГАМЖ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

НЯРАВ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ